

Манмин Мэдээ

№ 56 2018. 1-р сар 28ний өдөр

Бурханы алдар илүү их илчлэгдэх, 2018 он



2017-2018 шинэ оноо угтах мөргөл өмнөхөн И Жей руг Тэргүүн пастор 2017 оны сүүлийн Эзэний өдрийн үдээс хойшхи мөргөлийн дараа энэ жилийн тайлангын хурлыг удирдан явуулав. Мөн түүнчлэн 2018 оны турш Бурханы өгөхөөр бэлтгэсэн ерөөлийн тухай мөн орон нутагт болон дэлхийн өнцөг булан бүрд орших 11000 гаруй салбар сүмүүд болон хамтарсан сүмүүдтэйгээ хамт бүх итгэгчид залбиран, Бурхандаа алдар өргөх шинэ оны 4 залбирлын сэдвийн талаар тайлбарлаж өгөв.

1-р Сэдэв. Дахин бүтээлийн хүч чадлаар “Орон зайг удирдах”-г улам төгс болгох үйлчлэл

Иохан номын 14:12р ишлэлд “Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг хүн Миний хийдэг ажлуудыг ч бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Яагаад гэвэл Би Эцэгтээ очно” гэж айлдсанчлан дахин бүтээлийн хүч чадлаар орон зайг удирдах аргыг төгс суралцан сэтгэлдээ шийдсэнчлэн угийн дуугаар хамгийн дээд зэргийн үр жимс боловсруулах боломжтой.

Орон зайг удирдах гэдэг нь бүх тэнгэрийг дахин бүтээлийн хүчээр удирдан, хөдөлгөх гэх мэт байгаль орчинд түүнчлэн сүнсний ертөнцөд хүртэл боломжгүй зүйл үгүй болох явдал юм. Далайн хүчит давалгаа болон хар салхиний хүчийг сулруулах юм уу, чиглэлийг нь өөрчлөх, борооны үүлийг бий болгох ба шилжүүлж, ган гачигтай болон үерийн асуудлыг шийдэж, салхийг хөдөлгөн агаарын бохирдол, тоосонцорын асуудлыг шийдэж, урьдчилан сэргийлэх боломжтой бөгөөд мөн олон хүнийг өөрчлөн сүнсний ертөнцийг маш тодоор харах ч боломжтой юм.

2-р Сэдэв. “Чин үнэний сэтгэл ба төгс итгэл”-ийг хүсэн тэмүүлж хариулт авдаг баяр хөөрийн үйлчлэл

Еврей 10:22д “бузар мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд өөрсдийн зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, үнэн зүрхээрээ ойртон очигооё” гэж айлдсанчлан чин үнэн сэтгэл ба төгс итгэлд хүрвэл Түмэн цэргийн Эзэн Бурханы хайр ба ерөөлийг авах боломжтой юм.

Бурханы бэлтгэсэн ерөөлийн хаалганы өмнө ирсэн тул зохистой аягыг бэлтгэхийн тулд үнэн сэтгэл ба төгс итгэлтэй болохын тулд зүрх сэтгэлийн хөвч хөндөлтийг хийн, үнэнээр дүүргэх хэрэгтэй юм. Хичнээн гэмээр дүүрэн ертөнц байсан ч хоньчины хайр ба шударга ёсны үйлст итгэн, угийн гэрэл ба дуунд түшиглэн, хорон муу төдийгүй мөс чанарын атгаг байдал, зүрх сэтгэлийн угт хүртэл нуугдсан хорон муу шинж чанарыг хүртэл хаях боломжтой юм. Түүнчлэн илүү сайхан үзэсгэлэнтэй Шинэ Иерусалимд орохыг хүсэн тэмүүлж, итгэлээр өсч, итгэлийн хадан суурь, сүнслэг итгэл болон төгс сүнсний итгэл хүртэл өсч, ерөөлийн үед агуу баяр хөөрөөр дүүрэхийг хүсч байна.

3-р Сэдэв “Үнэний өргөө сүм”-г байгуулахын төлөө босч гэрэлтэх итгэгч нарын үйлчлэл

Исаиа 60:1д “Бос, гэрэлт. Учир нь чиний гэрэл ирж, Эзэний цог жавхлан чиний дээр мандаж байна” гэсний дагуу Эзэнийг хүлээн авч, Ариун Сүнсийг бэлгээр аван сүнсээр дахин төрснөөр сүнсний хүн, төгс сүнсний хүн болж босч гэрэлтэх боломжтой юм.

Энэ мэт босч гэрэлтсэн итгэгч нараар бий болсон сүм чуулган бол жинхэнэ үнэний өргөө

сүм бөгөөд, Бурханы зүрх сэтгэл ба хүсэл тунхаглагдан Ариун Сүнсний хүч чадлаар өвчин, сул дорой, чөтгөрт эзэмдүүлэгдэхээс чөлөөлөгдөж, гэр бүл, ажлын талбар, дахь асуудлуудаа шийдэгдэх зэрэг Бурханы гайхамшигт хүч илрэн гардаг юм. Эцсийн цаг үед Бурханы зорилго дотор баригдаж буй Их Өргөө сүм нь аврал авсан итгэгч нар ус мэт түрэн орж ирэх, үнэний өргөө сүм болохын хувьд босч гэрэлтэх итгэгч нарын бэлтгэгдэх хэмжээгээр их өргөө сүмийн босгон байгуулалт ч гэсэн илүү эрчимжих болно.

4-р Сэдэв “Сүнслэг хайр” илүү төгс болох сүм

1 Коринт13:13д “Эдүгээ итгэл, найдвар, хайр гурав үлддэг боловч хамгийн агуу нь хайр мөн” гэсний дагуу сүнслэг хайр нь Бурханы жинхэнэ хүүхэд болон Шинэ Иерусалим хотод орж чадах, алдрыг хүртэх хамгийн том сүнсний бэлэг юм.

Бурхан 2007 онд Тэргүүн пасторыг сэтгэлдээ нэг зүйлийг өвөрлөж, индэр дээрээс тунхаглавал түүнчлэн ерөөж өгнө гэж айлдсан ба тэр үед хүчтэй удирдамж авсан зүйл нь “Сүнслэг хайр” юм. Тиймээс энэ сүмд Бурханы хайр нь илүү гүн түвшинд орж ирэн, 2010 оноос “Хайрын Бурхан”-р итгэгч нарын зүрхэнд гүн суугдсан юм. Бурхан 2018 оноос сүнс зүгийн хайр улам төгс болж энэ өргөө сүмд илчлэгдэх болно гэж айлдсан билээ.

Орон зайн удирдах үйл явцаар дамжуулан гайхамшигт үйлчлэл нүдний өмнө үзэгдэх ивээлийн 2018 он, үнэн сэтгэл ба төгс итгэлийг эзэмшин, босч гэрэлтэн сүнс зүгийн хайрыг төгс авч, хоньчинтойгоо хамтдаа эцсийн үеийн хүсэл зорилгыг агуу ихээр хэрэглэгдэхийг хүсч байна.

Иерусалимд үхэх амь

“Яг тэр үед хэсэг фарисайчууд гарч ирээд Түүнд-Херод Таныг алахыг хүсэж байгаа тул эндээс холд, яв гэв. Есүс тэдэнд-Явж, тэр үнэгэнд Үзэгтүн, Би өнөөдөр, маргааш чөтгөрүүдийг зайлуулж, өвчинд нэрвэгдэгсдийг эдгээнэ. Гурав дахь өдөр нь Би Өөрийн зорилгоо гүйцээнэ гэж хэл. Харин Би өгөөдөр, маргааш, мөн нөгөөдөр ч замд явах ёстой. Учир нь эш үзүүлэгч Иерусалимын гадна хөнөөгдөх ёсгүй юм” (Лук 13:31-33).



И Жей руг пастор

Нэгэн өдөр Есүс дээр хэсэг фарисайчууд хүрч ирэн “Херод Таныг алахыг хүсч байна” гэлцэн Иерусалимаас явахыг ятгаж байлаа. Есүс нь тэмдэг гайхамшигийг үйлдэн хүмүүсийн ёс бус байдлыг зэмлэж байгаа тухай сонссон Херод нь хэдийн үхсэн баптисм хүртээгч Иоханыг дахин амилж гэж бодон айж байсан юм (Матай 14:2).

Энэ тухай Есүс түүнийг “Үнэг” гэж нэрлэн түүнд дамжуулах үгийг хэлсэн байдаг. Мөн “Эш үзүүлэгч Иерусалимын гадаа хөнөөгдөх ёсгүй” гэж эцэст нь нэмж хэлсэн байдаг. Энэ үг нь библийн тайлахад хэцүү утгатай ишлэлүүдийн тоонд ордог бөгөөд энэ нь чухам ямар сүнс талын утгатай вэ?

1. Есүс Херод хааныг “Үнэг” гэж нэрлэсэний учир

Херод хаан Есүсийг хөнөөх гэж байна гэсэн фарисайчуудын үгэнд Есүс Лук номын 13:32д “Есүс тэдэнд-Явж, тэр үнэгэнд Үзэгтүн, Би өнөөдөр, маргааш чөтгөрүүдийг зайлуулж, өвчинд нэрвэгдэгсдийг эдгээнэ. Гурав дахь өдөр нь Би Өөрийн зорилгоо гүйцээнэ гэж хэл” гэж айлдсан байдаг.

Тэгвэл яагаад Херодийг үнэгтэй зүйрлэсэн юм бол? Хэдийн баптисм хүртээгч Иоханыг хөнөөсөн Херод хаан энэ удаад Есүсийг хүртэл хөнөөх гэсэн санаа нь яг л жижүүцэм атгаг үнэгний үйлдэлтэй адил учир юм. Есүс нь ядууст туслаж, төрөл бүрийн өвчтэй болон сул дорой хүмүүсүүдийг эдгээж, тэнгэрийн орон

ба там, шүүлтийн талаар мэдүүлж, эрх мэдэлт хүчний үйлсүүдээр дамжуулан Бурханы амьд оршин буйг үзүүлж өгөн, ямар ч байсан нэг хүнийг ч илүү авралд хүргэхийн төлөө өдөр шөнөгүй бүх хүчээ зориулсан юм. Энэ мэт зөвхөн сайныг л үйлдсэн Есүсийг хөнөөх гэдэг нь Бурханы хаанчлалд саад учруулсан хэрэг мөн Бурхантай тэрсэлдэж буй үйлдэл тул “үнэг” гэж нэрлэсэн юм.

Өнөө үед ч гэсэн үнэг мэт хүмүүс байсаар байна. Ариун Сүнсний үйлс хүчтэйгээр илрэн гарч Бурханы алдар илэрхийлэгдэн байгаа сүмүүд рүү хандан харин ч эсрэгээрээ гаж буруу гэж дүгнэж шүүдэг, хавчдаг хүмүүсийн бодит төрх үнэг мэт дүр төрхтэй адил юм. Магадгүй хэл яриа ба үйлдлээр Бурханы хаанчлалд саад болсоноороо Эзэнээс үнэг гэж нэрлэгдэх хүн байхгүй байх хэрэгтэй юм.

2. Өнөөдөр ба маргааш түүнчлэн гурав дахь өдөр гэдгийн сүнс талын утга

Тэгвэл Есүсээс “Би өнөөдөр, маргааш чөтгөрүүдийг зайлуулж, өвчинд нэрвэгдэгсдийг эдгээнэ. Гурав дахь өдөр нь Би Өөрийн зорилгоо гүйцээнэ” гэсэн үгэнд агуулагдсан сүнс талын утга нь юу вэ?

Эндээс “Өнөөдөр ба маргааш” гэдэг нь Есүс тун удалгүй загалмай дээр цовдлогдон үхэх хүртэл Бурханы ажлыг хийх хугацааг хэлж байгаа юм. Мөн “Би өнөөдөр, маргааш чөтгөрүүдийг зайлуулж, өвчинд нэрвэгдэгсдийг эдгээнэ” гэдэг нь Есүс Бурханы төлөвлөгөөн дунд загалмай дээр цовдлогдохой өмнө хүртэл Бурханы ажлыг тасралтгүй гүйцэтгэх талаар айлдсан үг юм.

Тэгвэл “Гурав дахь өдөр нь Би Өөрийн зорилгоо гүйцээнэ” гэдэг нь Есүс үхээд 3 хоногийн дараа дахин амилсанаар үхлийн хүчийг ялан дийлж, хүн төрөлхтөнийг аврах Бурханы зорилгыг төгс биелүүлсэн гэсэн ирээдүйг зөгнөн айлдсан үг юм.

Ийм загалмайн хүсэл зорилго ба дахин амилалтад итгэн, Эзэнтэй нэгдсэн хүн нь нүглийн хөлс бол үхэл гэгдэх хуулийн хараалаас чөлөөлөгдөж, авралд хүрэх боломжтой юм (Ром 6:23, 10:9). Бүрэн үхээд дахин амьдрах дахин

амилалт байж л хүн төрөлхтөнийг аврах Бурханы хүсэл төгс болох учир үүнийг зааж айлдсан гурав дахь өдрөө Өөрийн зорилгоо гүйцээнэ гэж айлдсан юм.

Ингэж хүн төрөлхтөний авралын замын тухай бүх үйл явдлыг өнө эртнээс ч өмнө Бурханы удирдамж дор биелэгдэн явсаар Бурханы зөвшөөрөлгүй хэн ч Есүсийн үйлдэж буй ажлыг саатуулж чадахгүй ба Есүс ч үхэхгүй юм.

Тиймд Есүс аврагч Эзэний үүргийг гүйцэтгэхийн төлөө энэ газар дээр ирэн, үйлчилж байх хугацаандаа ямар ч хавчлага болон аюулд авталгүй, цаг нь ирж, Бурхан зөвшөөрснөөр хүн төрөлхтөний бүх гэмийг өмнөөс нь үүрч, загалмай дээр цовдлогдон нас бараад дахин амилсанаар Бурхан Аавын хүслийг төгс биелүүлсэн юм.

3. “Эш үзүүлэгч Иерусалимын гадна хөнөөгдөх ёсгүй” гэдэг үгийн утга болон сургамж

“Харин Би өгөөдөр, маргааш, мөн нөгөөдөр ч замд явах ёстой. Учир нь эш үзүүлэгч Иерусалимын гадна хөнөөгдөх ёсгүй юм” гэж айлдсаны дагуу Есүс бүх хавчлага ба хүнд байдлуудыг ялан дийлж, загалмайн дээрх ичгүүрт байдлыг ч үл тоон явах замаа зөвхөн амеенаар явсан тул дахин амилж, дээш одон, Бурханы сэнтийн баруун талд суух алдрыг хүртсэн билээ.

Гэтэл “эш үзүүлэгч Иерусалимын гадна хөнөөгдөх ёсгүй юм” гэсэн бөгөөд библийг сайтар ажиглавал Есүс нь Иерусалим хот дотор бус хотын гадна байх Голготын толгод дээр амиа зориулсан байдаг Элч Паул, Петр нар ч Иерусалим хот дотор бус Ромд амиа зориулсан байх. Есүсийн шавь нар ч гадаадын энд тэнд олон газар сайн мэдээ тарааж байгаад амиа зориулсан байдаг бичигдсэн байдаг. Тэгсэн ч гэсэн Есүсийн ингэж айлдсан нь ямар учиртай вэ?

Иерусалим гэдэг нь амар тайвны хот гэсэн утгатай бөгөөд Исаиа 52:1д “Ариун хот Иерусалим” гэсэн байдаг. Иерусалимд Бурханы өргөө байдаг Бурханы зүрх сэтгэл ба хүсэл байдаг хотынхоо хувьд сүнс талаар Бурханы үг сургаалийг илэрхийлж байгаа юм (Исаиа 2:3).

Тиймд “Эш үзүүлэгч Иерусалимын

гадна хөнөөгдөх ёсгүй” гэдэг нь эцэстээ эш үзүүлэгч нь Бурханы үгэн дотор амьдарч байгаад түүн дотроо үхнэ гэсэн утгатай юм. Хэрэв эш үзүүлэгч гэсэн мөртлөө Иерусалим гадна өөрөөр хэлбэл Бурханы үгийн гадна амьдардаг бол тэр худалч, хуурамч эш үзүүлэгч юм. Жинхэнэ эш үзүүлэгч нь ямар ч сорилт хавчлага ирсэн ертөнцийн эрх мэдэл, нэр алдар уруу татах гэсэн ч Бурханы үгээс холдож болохгүй бөгөөд амьдасран ч үхсэн үгэн дотор байх ёстой юм.

Энэ нь зөвхөн эш үзүүлэгч бус Бурханы үр хүүхдүүдэд ч хамаарах үг юм. Бурханы үр хүүхэд бол мэдээж Бурханы үгийн дотор амьдрах ёстой бөгөөд (1 Иохан 1:7), түүний дотор амьдарвал аяндаа үгэн дотор үхэх болдог. Амьд байх гэсэн бардам сэтгэл мөхөж, өөрийн бодол санаа болон онол үзэл баримтлал үгүй болдог учир юм. Элч Паулын “Би өдөр бүр үхдэг” гэсэн гэрчлэл шиг үгийн дотор бүрэн үхнэ гэдэг нь Иерусалимд үхэх амьдрал бөгөөд Бурханы үгэн дотор амьдрах явдал юм.

Бурханы үгэн дотор амьдарвал өөрийн “Би”-г үхүүлэх Иерусалимд үхэх амьдрал бөгөөд энэ нь жинхэн мөнх амь ба мөнхийн амьдрал юм. Гэхдээ Бурханы үгийн гадна амьдарвал өөрийн “Би” нь Иерусалимын гаднах үхэл бөгөөд энэ нь мөнхийн үхлийн зам юм. Тиймээс Эзэн айлдахдаа “Намайг Эзэн минь, Эзэн минь гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцгийн хүслийг биелүүлдэг хүн орно” (Матай 7:21), “...Хэрэв чи амьтай болохыг хүсэж байгаа бол тушаалуудыг сахь гэв” (Матай 19:17) гэж айлдсан байдаг.

Хайрт итгэгч та бүхэн, “Иерусалим дотор үхэх амьдрал” гэдэг нь Бурханы үгэн дотор амьдарч, үхсэн түүний дотор үхэх амьдралаар амьдарснаар Бурханы өмнө хүлээн зөвшөөрөгдөн алдарыг өргөхийг хүсье. Бүр цаашилбал Иерусалим дотор төгс үхэх амьдралаар амьдармагцаа эцэстээ мөнхийн тэнгэрийн оронд Шинэ Иерусалим ариун хотод мөнхөөс мөнхөд амьдрахыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org

Шри Ланк•Египет•Пакистан номлогчдын семинар болон гар алчуурын цуглаан

Гил Тэ шиг пастор удирдамж дор 11-р сарын 27ноос-12-р сарын бныг хүртэл Шри Ланк Египет, Пакистанд номлогчдын семинар ба Эдгэрэл ивээлийн цуглаан (Үйлс 19:11-12) өнгөрлөө.



▲ Шри Ланк дахь номлогчдын семинар (11.28)



▲ Шри Ланкд болсон Эдгэрэл ивээлийн цуглаан (11.29)



▼ Египетэд болсон номлогч нарын семинар(12.1)



▼ Египетэд болсон Эдгэрэл ивээлийн цуглаан (12.2)



Үр жимстэй амьдрал

Тариачин арвин ургац авахын төлөө эхлээд үр суулгах хэрэгтэй байдаг шиг, сүнс талаар ч арвин үр жимс авахын суулгах хэрэгтэй юм. Ямарч нөхцөлд баяр хөөртэй байхыг хичээж, баяр хөөрийн үрийг суулгах тусам, баяр хөөрийн үр жимс боловсорч, үргэж баяр хөөртэй байж, бүх зүйлд талархах гэсэн үгийн дагуу чин сэтгэлээсээ талархах үед л талархалын ивээл ихээр бууж, талархах сэдвүүд олон болдог. Мөн залбирал ч гэсэн хичээнгүйлэн үр суулгасаар илүү агуу залбирлын хүчийг авч, хариултын үр жимсийг хураан авах болдог. Тиймд дээрх гурван зүйлийг яаж суулгаж, хурааж авах тал дээр ярилцацгаая.

Ямар ч тохиолдолд үргэлж баяртай байдаг уу?

Бид авралын баяр хөөрөөр л дүүрэн байхад ямар ч нөхцөлд үргэлж баяртай байж чаддаг. Мөнхийн тамын шийтгэлээс чөлөөлөгдөж, төсөөлж ч чадахгүй тэнгэрийн орны алдрыг өгч, бүхнийг чадагч Бурханыг Аав гэж дуудах гайхамшигтай ерөөлийг авсан учраас юм. Элч Паул нь сайн мэдээ тарааж явахдаа үй олон хавчлага дарамт, зовлонг амссан ч түүний зүрх сэтгэл дэх баяр хөөрийг хэн ч булааж чадахгүй байлаа. Ташуурдуулж, шоронд хоригдсон ч харин ч Эзэн дотор үргэлж баяртай

бай гэж уриалж байсан юм (Филиппой 4:4). Магадгүй одоогийн бодит байдал дахь хүнд байдлаас болж авсан ивээлээ мартаж юм уу, сэтгэлээх унаж, гутарч, махан биеийн бодол дотроо сүнсний бялхам байдлаа алдаж, авсан үүргээ орхиж, хөндийрч байна уу, гэдгээ мөн байх ёстой байр сууриа арай ядан сахиж, албадлагаар үүргээ биелүүлж байна уу гэдгээ эргэн харах хэрэгтэй юм. Бурханы ивээл ба тэнгэрийн орны хүсэл тэмүүлэл зүрх сэтгэлд дүүрэн байвал ямар ч үед тэр баяр хөөр нь амийн ус мэт ундарч, хүнд байдлыг маш хурдан ерөөлөөр өөрчилж сүнсээр ч хурдан өсөх боломжтой.

Бурханы хайранд итгэн, бүх зүйлд талархалаа илэрхийлдэг үү?

Бүтээгч Бурхан болон хамгийн сайныг л өгдөг Бурхан Аавд итгэдэг бол ямар ч сорилт авсан зөвхөн талархал л гардаг. Өөрийн дутагдалтай байдлаас үнэний дотор төгс үйлдэж чадахгүй байсан ч “Бурхан намайг хайрладаг” гэдэг үнэн болон “Миний бүх байдлыг мэдэж, бүх тал ялах хүчийг өгдөг” гэдэгт баттай бол эцсээ хүртэл ш итгэлээрээ талархан, бүх зүйлд сайнаар үйлдэн, ерөөгдөн өөрчлөгддөг юм.

Хэрэв тавгүйтэж бухимдан, уйтгарт автан, гоморхдог бол хичнээн өчүүхэн итгэлтэй болохоо ухаарах хэрэгтэй юм. Итгэлтэй бол өөрөө сул дорой байх тусам, дорой нэгэнийг агуу болгож, дутагдалтай нэгэнийг төгс болгодог Бурханы хүчинд талархаж чаддаг ба байдал хэцүү байх тусам, ерөөж өгөх Бурханд талархдаг юм. Тэгэх л үед Бурхан ямар ч нөхцөлд төгс талархалын үгийг л хэлдэг итгэлд хариулж өгөн, илүү арвин талархалын ургац авахын тулд ерөөж өгдөг юм.

Үйлстэй итгэлээр тасралтгүй залбирч байна уу?

Үргэлж баяртай байж, талархдаг хүн нь Ариун Сүнс бялхам байдалд залбирвал илүү гүн түвшин рүү нэвтрэн орох болдог. Тэгвэл Бурхантай ярилцаж буй залбирлын цаг нь хэцүү төвөгтэй санагдвал Бурханыг хайрлаж байгаа хэрэг биш бөгөөд ерөөл авах ч боломжгүй юм. Хэрэв залбирал нв зогсонги болсон бол хэр зэрэг баяртай болон талархаж байгаагаа эргэж харах хэрэгтэй юм.

Залбирал нь хэцүү байх тусам Бурханы ивээлд цангасан сэтгэлээр

илүү гүнзгий залбирах ёстой бөгөөд чин сэтгэлээсээ дуудан залбирч, нэг нэг шатаар сүнс талаар өргөжих хэрэгтэй.

Хэрэв залбирал хийсэн ч ерөөл авч чадахгүй мэт байвал тэр хэмжээний итгэлийн үйлс дутуу байна гэдгээ ухаарах хэрэгтэй юм. Үйлс дагалдаж байж Бурхан хамт байн, ерөөж, илүү том аяга бий болгож, цаг нь ирвэл том хариулт ба ерөөлийг авах боломжтой юм. Баяр хөөр, талархал, мөн үйлстэй итгэлээр тасралтгүй залбиран сүнс махан талын үзэсгэлэнт ургац хураахыг хүсье.

“Ариун сайн мэдээгээр дамжуулан ерөөл Эзэний боол болсон юм”



Яо Лан шиан пастор,
56 нас, Тайвань, Шинжан Манмин сүм



Залуу үедээ сайн мэдээг сонсож, сүмд үйлчилж байх үед, амлан залбирлыг Бурханд өргөсөн юм. Авто ослын улмаас ухаангүй болсон аавыгаа амьдруулж өгвөл амиа зориулан Эзэний төлөө зүтгэе гэсэн залбирал байсан юм. Тэгээд аав минь эргэн амьдарсан юм.

Тухайн үед 39 настай байхдаа хүүхдүүд маань балчир байсан ч библийн сургууль элсэн орж, Христчин урлагын чиглэлээр 4 жил сурсан юм. Бага байхын хөгжимд дуртай тул сүмд төгөлдөр хуур тоглох юмуу найрал дууны удирдаачаар үйлчилж байсан юм. Гэтэл миний хүслээс тэс ондоогоор Бурхан намайг хүмүүсийн авралын төлөө үйлчилдэг Эзэний боолын замаар удирдсан юм.

2005 онд Сингапурын нэг том цуглаан Тайваньд сайн мэдээний дагалдагч бэлтгэх сургалт эхлэхэд сүмийнхээ залуучуудыг удирдан оролцсон юм. Энэ сургалтын хугацаанд Бурхан үг сургаалиар зэвсэглэх тал намайг удирдаж, тэр сүмд библийн хичээлийг үзэж дуусаад Сингапур төдийгүй, Малайз, Хятад хүртэл сайн мэдээ тараахаар биднийг бэлдсэн юм.

Тэгж байгаад 2008 онд Сингапурт уулзаж байсан Шим Эстэр сүмд үйлчлэгчээс Манмины тухай, Манмин магтаалын тухай анх сонссон юм. Би энэ дэлхийд Бурханы өгсөн магтаал дуу байдаг гэдэгт маш гайхан Манмин төв сүмд зочилж үзсэн юм. Манмин магтаал бол маш ивээлтэй бөгөөд миний хүсэж байсан магтаал байлаа. Мөн И Жей руг Тэргүүн пасторын залбирлаар далайн шорвог ус амтат усаар өөрчлөгдсөн Мүан амтат усны хүрээлэн (Е. Гарсан нь 15:25) д хүртэл зочилж үзсэн юм. Гайхамшигтай энэ газар ирэхэд миний ч гэсэн сүнсний нүд нээгдэн тэнгэр элч элч тойрон хүрээлж, намайг харж байгааг харман юм. Үнэхээр маш аз жаргалтай байсан нулимс аяандаа гарч байлаа.

Ийм сүнс талын мэдрэмж үзсэний дараа И Жей руг тэргүүн пастор гэж чухам ямар хүн болохыг илүү мэдэхийг хүсч байлаа. Түүний “Загалмай үг”, “Итгэлийн хэмжээ”, “Тэнгэрийн орон” зэрэг номыг шимтэн уншингаа Бурханы хайр болон ариун сайн мэдээний гол цөмийг ухаарч, сүнс талаар дахин төрөх мэт болсон юм.

Есүс Христээр дамжуулан авралын зорилго агуулагдсан “Загалмай үг” номоос маш их ивээл авсан бөгөөд

ялангуяа “Могойд насан туршдаа тоос идэх болно” гэсэн үг нь дайсан диавол сатан нь гэм нүгэл дотор амьдардаг махан биеийн хүмүүсийг өөрийн болгож, сорилт, гай зовлонг өгдөг гэх сүнс талын утга учрыг ойлгох үед тэр маш тодорхой хариултанд маш гайхсан юм.

Библид агуулагдсан жинхэнэ утгыг ухааруулж өгдөг ариун сайн мэдээ байдагт үнэхээр талархаж, энэ ивээлт мэдээг сайн мэдээ тараах газар болгондоо дамжуулсаар байсан юм. 2009 онд Израйль Иерусалимд болсон “Израйлийн нэгдсэн их цуглаан”д хүртэл оролцсон юм. Миний нүдний өмнө алхаж чадахгүй хүмүүс таягаа хаяцгааж, тэргэнцэрээсээ босч алхаж, хараа нь сайжирсан хүмүүс нүдний шилээ авч хаяж, үй олон Ариун Сүнсний галаар төрөл бүрийн өвчнөөсөө эдгэрч баяр хөөртэйгөөр гэрчилжээж байлаа.

И Жей руг Тэргүүн пасторын залбирлын нөлөө ба эрх мэдэлт хүчний үйлс нь үнэхээр агуу байлаа. 2010 Солонгосын Мүжүд болсон “Манмин зуны цуглаан”д оролцон Бурхан хамт оршдог сүм болохыг илүү баттай мэдэх болсон юм. Үүний дараа би Бурханы удирдамжаар сүмийг байгуулж, 2014 онд албан ёсоор Манмины салбар сүм болсон юм.

Манай сүм нь GCN (Жи Си Эн) телевизээр төрөл бүрийн мөргөл ба залбирлын цагт оролцон ерөөл авч байна. 7 жил жирэмсэлж чадахгүй байсан итгэгч жирэмсэлж, тал бие нь саажсан байсан залуу төгс эдгэрсэн юм. Миний хувьд түлэгдэлт, цээжний зовиур өвчин, нүдний хараа муудах өвчинөөсөө эдгэрч, Мүан амтат усаар нүдэндээ давхраатай хүртэл болсон юм.

Түүнчлэн гэрийн цуглаанаас эхлэсэн бид итгэгч нар эд хөрөнгөөр ерөөгдөж байгаа тул одоо өөрийн байртай сүм болж өргөжсөн билээ. Амийн үг сургаалиар өөрчлөгдсөн амьдрал, түүн доторх ерөөлийн гэрчлэл бялхан байгаа тул би үнэхээр ерөөгдсөн Эзэн боол билээ. Халлелүяа !



Тайвань Шинжа Манмин цуглаан нь GCN телевизээр мөргөл ба залбиралд оролцон итгэгч нар ерөөл авч байна.



Пэ Жун сог сүмд үйлчлэгч,
62нас, Чанвон Манмин сүм

“Чихний хэнгэрэгийн архаг үрэвсэл, сэтгэл тавгүйтлээсээ эдгэрч, чихний сонсгол сэргэсэн юм”

Би 15 настайдаа баруун чихэндээ ус оруулснаас болж, мөн тухай үед сайн эмчлүүлж чадаагүйгээс болж, чихний хэнгэрэгний архаг үрэвсэлтэй болсон юм. 50 иад жилийн турш булаг гоожиж, үргэлж хөвөнгөөр цэвэрлэх ёстой ба хэнгэрэг нь хайлж ямарч дуу сонсохгүй болсон юм. 2012 оноос Чанвон манмин цуглаан явдаг болж чихний булаг гоожихоо байсан юм.

Тэгж байгаад 2017 оны 5-р сард зүүн талын чих гэнэт сонсгол бүдэг болсон юм. Эмнэлэгт үзүүлэлт дунд чихний сонсгол муудсан гэсэн бөгөөд эмч бүрэн эмчлэглэгдэх хэцүү гэсэн ба сонсголын аппарат хэрэглэхийг надад зөвлөсөн юм. Насан туршдаа зүүн чихээрээ амьдарч байсан миний хувьд сайн сонсохгүй ийм байдалтай болсон нь маш хүнд санагдсан юм. Итгэлээрээ Бурханд хандан эдгэрэх гэж итгэлийн суурь сургаал болох “Загалмай үг” сургаалийг дахин дахин сонссон юм.

Нэгэн удаа шөнө унтахын өмнө сургаалиа сонсоод тэргүүн пасторын өвчин эдгэх залбирлыг авсан ба тэр шөнө зүүдлэхдээ маш дөлгөөхнөөр инээмсэглэн над дээр ирээд “Хийвэл болно доо” гээд чин сэтгэлээсээ залбирал хийж өгсөн юм. Би зүүдэндээ залбирал авсаны дараа үнэхээр зүүдэндээ ч юм шиг үгүй ч юм шиг миний чихэн доторх мэдрэлийн эд эсүүд байр байрандаа орж байгаа юм шиг мэдрэмж авсан юм.

Өглөө босоод үзтэл сэтгэл санаа ч өмнөхөөсөө илүү бүр ч цовоо сэргэлэн болсон байв. Угаалгын өрөө рүү ороод усны цоргыг нээтэл “шоррр” гээд ус урсах чимээ сонсогдлоо. Мөн өөрийнхөө алхаж чимээ, печь эргэж байгаа чимээг ч гэсэн сонсож байлаа. Үнэхээр гайхалтай нь зүүн талын чих төдийгүй огтс сонсодоггүй баруун чих маань хүртэл бүдэгхэн чимээ сонсогдож эхлэсэн байлаа.

Эмнэлэгт очоод шалгаж үзтэл зүүн талын чихний сонсгол сэргэж, бараг хэвийн хэмжээнд хүрсэн байгааг үзээд эмч маш их гайхаж байлаа. 8-р сард “Манмин зуны цуглаан” ы эдгэрлийн цуглаанд тэргүүн пасторын залбирлыг авсан дараа зүүн талын чихний ялимгүй шуугиан ч гэсэн бүрэн арилж, мөн баруун чих маань өмнөхөөсөө илүү сайн сонсдог болсон юм. Халлелүяа!

Анагаах ухаанаар эдгэрэхийн аргагүй миний чихийг эдгээж өгсөн бүтээгч Эзэн Бурхандаа бүх л алдар талархалыг өргөө. Мөн залбирал хийж өгсөн тэргүүн пастордаа талархалаа илэрхийлье.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
12-р хороо, Хангайн 3-57 тоот
Улаанбаатар Ариун баярт мэдээ
чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:
Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminnews@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин